



**БАГАНУУР ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 01 сарын 03 өдөр

Дугаар A/01

Улаанбаатар хот

**2017 оныг Төрийн албан хаагчдын
хариуцлагыг дээшлүүлэх жил болгон
зарлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдыг чадваржуулах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор 2017 оныг Төрийн албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлэх жил болгон зарласугай.


2. "Төрийн албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлэх жил"-ийн ажлын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний санал боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга
Гишүүд


Засаг даргын орлогч
Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
бөгөөд ажлын албаны дарга
Засаг даргын Тамгын газрын дарга
Хотын ерөнхий менежер бөгөөд
Захирагчийн ажлын албаны дарга
Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн дарга
Санхүү, төрийн сангийн хэлтсийн
дарга
Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
хэлтсийн дарга
Боловсролын хэлтсийн дарга
Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын
хэлтсийн дарга
Эрүүл мэндийн төвийн эмчилгээ
эрхэлсэн орлогч дарга

3. Хийх ажлын төлөвлөгөөг боловсруулж 2017 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн дотор батлуулж, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэг /Т.Отгонболд/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.САНДАГ-ОЧИР



Багануур дүүргийн Засаг даргын 2017
2017 оны 01 дугаар сарын 24-ны өдрийн
#26 дугаар захирамжийн хавсралт

“ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЖИЛ”-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2017 оны 01 дүгээр сарын 24

Багануур дүүрэг

ЗОРИЛГО: Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд Төрийн албан хаагчдын хариуцлага, ёс зүй, ажлын байрны соёлыг дээшлүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэхэд оршино.

Д/д	Хийх ажил	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах эзэн, байгууллага	Хүрэх үр дүн
№	1	2	3	4	5
Нэг: Төрийн албан хаагчдын хариуцлага, ёс зүй, ажлын байрны соёлыг дээшлүүлэх зорилтын хүрээнд:					
1.1.	Зорилтот жилийн ажлын нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулах	Төрийн албан хаагчдыг бүрэн хамруулж, хугацаандаа хийгдсэн байх	01.26	Жилийн ажлыг зохион байгуулах ажлын хэсэг	Төлөвлөгөө төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдад танилцуулагдсан байна.
1.2.	Төрийн албаны стандарт, дүрэм журмыг мөрдөж ажиллах	ЗДТГ-аас төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, гарааны түвшин тодорхойлох	2, 10 сард	ЗДТГ-ын ТЗУХ	Байгууллагуудын дотоод үйл ажиллагааны түвшин бодитоор тодорхойлогдсон байна.

	“Ажлын цаг ашиглалтын журам”-ыг боловсруулан, улирал бүр үр дүнг тооцож ажиллах	01 дүгээр сараас	Төрийн байгууллагуудын удирдлагын баг	Төрийн албаны стандартын хэрэгжилт сайжирсан байх.
	Ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг боловсронгуй болгож, мөрдөж ажиллах, энэ талаар мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулах		Төрийн байгууллагуудын удирдлагын баг, ажилтан албан хаагчид	
	Үр дүнгийн болон Хөдөлмөрийн гэрээг холбогдох хууль, журмын дагуу байгуулж, хэрэгжилтийг тооцож ажиллах		Төрийн байгууллагуудын, удирдлагын баг	
	Байгууллага бүр Төрийн албан хаагчдын ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг боловсруулан хэрэгжүүлж ажиллах	2 сараас	Төрийн байгууллагуудын удирдлагын баг	
	Төрийн албан хаагчдын хувийн хэргийг холбогдох журмын дагуу бүрдүүлж, баяжилтыг тогтмол хийж ажиллах	Жилдээ	Төрийн байгууллагууд	
	Төрийн албан хаагчдын судалгааны нэгдсэн сан бүрдүүлэх	1-р улирал	ЗДТГ-ын ТЗУХ, Төрийн байгууллагууд	
	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажиллах	Жилдээ	Төрийн байгууллагууд	
	Ёс зүйн дүрмийг батлах, мөрдүүлэх	1-р сараас	Төрийн байгууллагуудын удирдлагын баг	
	Ёс зүйн хороо байгуулж, түүний ажиллах журмыг боловсруулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж	1 сараас	Төрийн байгууллагуудын удирдлагын баг	

		ажиллах. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой сэтгэл ханамжийн судалгааг иргэдээс авч, дүгнэлт хийж ажиллах.	Хагас, бүтэн жилээр	ЗДТГ, Төрийн байгууллагууд	Төрийн үйлчилгээний талаар иргэдийн сэтгэл ханамж дээшилсэн байна.
1.3	Удирдлагын манлайллын чиглэлээр	Байгууллагын үндсэн үзүүлэлтүүдийг өмнөх оныхоос дээшлүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулах	Жилдээ	Төрийн байгууллагуудын удирдлагын баг	Үндсэн үзүүлэлтүүд өмнөх оныхоос ахисан, удирдлагын манлайлал дээшилсэн байх.
		Манлайллын чиглэлээр сургалт үйл ажиллагаанд тогтмол хамрагдаж өөрийгээ хөгжүүлэх	Жилдээ	Төрийн байгууллагуудын удирдлагын баг	
		Ажилтан, албан хаагчдыг багаар ажиллах чадварт сургаж, хамт олонч байдлыг төлөвшүүлэх	Жилдээ	Төрийн байгууллагуудын удирдлагын баг	
1.4	"5 S"-ийн зарчмыг хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллах	"5 S"-ийн зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд сургалт зохион байгуулж, туршлага судлуулах.	2 сард	ЗДТГ-ын НХХ, Багануур ХК, Төрийн байгууллагуудын удирдлагын баг	Ажлын байрны соёл, эмх цэгц сайжирч, ажлын бүтээмж нэмэгдэнэ.
		Байгууллага бүр "5 S"-ийн зарчмыг хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллах	Улирал бүр	Төрийн байгууллагуудын удирдлагын баг	
		"5 S"-ийн зарчмыг хэрэгжүүлэх аян зохион байгуулж, дүгнэж, урамшуулах.	2 сараас 11 сар	ЗДТГ-ын Ажлын хэсэг, Төрийн байгууллагууд	
Хоёр: Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилтын хүрээнд:					
2.1	Авлига, ашиг сонирхлын	Авлигын эсрэг хууль, Нийтийн	Жилдээ	ИТХ-ын ажлын алба,	

	зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлуудыг зохион байгуулах	албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах		ЗДТГ, Төрийн байгууллагуудын удирдлагын баг	Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй хамт олон төлөвшиж, мэдээллийн ил тод байдал хангагдсан байна.
		Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах	Жилдээ	Төрийн байгууллагууд	
		Ажилтнуудыг нийтийн албанд шинээр томилохдоо холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах	Жилдээ	Төрийн байгууллагууд	
		Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах	Жилдээ	Төрийн байгууллагууд	

Гурав: Төрийн албан хаагчдыг сургаж, чадавхжуулах болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилтын хүрээнд:

3.1	Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийг боловсруулж, батлуулах.	1-р улиралд	ИТХ, Ажлын хэсэг, Төрийн байгууллагууд	Хөтөлбөр хугацаандаа батлагдаж, тодорхой үр дүн гарсан байна.
		Хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг тооцож ажиллах.	Жилдээ	ИТХ-ын ажлын алба, ЗДТГ-ын Ажлын хэсэг, Төрийн байгууллагууд	
3.2	Төрийн албан хаагчдыг сургаж, чадавхжуулах.	Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр сургалт зохион байгуулах	1-р улиралд	ЗДТГ-ын ТЗУХ, Төрийн байгууллагууд	Төрийн албан хаагчдын мэдлэг,
		Төрийн албан хаагчийн ёс зүй, удирдлагын манлайллын чиглэлээр сургалт зохион	2-р улиралд	ДИТХ-ын төлөөлөгчид, ЗДТГ-ын ТЗУХ, НХХ, төрийн	

		байгуулах		байгууллагууд	ур чадвар дээшилнэ.
		Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр сургалт зохион байгуулах	2-р улиралд	ЗДТГ-ын СТСХ, Төрийн байгууллагууд	
		Авлига, хууль эрх зүйн чиглэлээр сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	Улирал бүр	ИТХ-ын ажлын алба, ЗДТГ-ын ТЗУХ, Төрийн байгууллагууд	
		“Дүүрэгт тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам” сэдэвт онол практикийн бага хурал зохион байгуулах	9-р сард	ЗДТГ, Төрийн болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагууд	Тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх оновчтой санал, санаачлага гарсан байна.
		Төрийн албан хаагчдын дунд ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулах	10-11 сард	ЗДТГ, Төрийн байгууллагууд	Төрийн албан хаагчдын ур чадвар нэмэгдсэн байна.
3.3	Төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх	Төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг ханган ажиллах	Жилдээ	Төрийн байгууллагууд	Судалгаанд тулгуурлаж, нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байна.
		Байгууллагын дотоод журмыг боловсронгуй болгож, төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар тодорхой заалт тусгаж, хэрэгжүүлэх, үр дүнг тооцох	Жилдээ	Төрийн байгууллагууд	
Дөрөв: Бусад ажлын хүрээнд:					
4.1	Зорилтот жилийн ажлын хаалтын үйл ажиллагааг зохион байгуулах	Жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийж үр дүнг тооцох	12 сард	ИТХ-ын ажлын алба, Жилийн ажлыг зохион	Зорилтот жилийн ажлын төлөвлөгөө

				байгуулах ажлын хэсэг, ЗДТГ	бүрэн хэрэгжиж, төрийн албан хаагчдын ур чадвар, хариуцлага нэмэгдсэн байна.
		Зорилтот жилийн ажлын хүрээнд идэвхи санаачлагатай ажилласан байгууллага, хамт олныг шалгаруулж урамшуулах ажлыг зохион байгуулах	12 сард	ИТХ-ын ажлын алба, Жилийн ажлыг зохион байгуулах ажлын хэсэг, ЗДТГ	

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН: ЖИЛИЙН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ